



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Зүүнбүрэн сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2023/120-НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.open.audit.mn

Сүхбаатар сум
2023 он

Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа

Утас: 70363040 Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Батмөнх

Утас: 70363036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn

Аудитыг гүйцэтгэсэн: ЦЭСБ-Аудит ХХК

Утас: 95112689 Цахим хаяг: tsesb.audit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Аудитын дүгнэлт.....
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
 - 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа
 - 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....
 - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....
 - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт.....
 - 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....
4. Аудитын тайлан.....
 - 4.1 Ерөнхий зүйл
 - 4.2 Материаллаг байдал
 - 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....
 - 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
 - 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
 - 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал
5. Аудитын илрүүлэлт
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт

БШУС	Боловсрол, шинжлэх ухааны сайд
БШУГ	Боловсрол, шинжлэх ухааны газар
БШУЯ	Боловсрол, шинжлэх ухааны яам
ЗГ	Засгийн газар
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ХНХС	Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

ЗҮҮНБҮРЭН СУМЫН
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ
Х.ӨЛЗИЙСАЙХАН ТАНАА

2023.02.25 № СНА 2023/120-НА-СТД-743
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Зүүнбүрэн сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Зүүнбүрэн сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Сэлэнгэ аймгийн Зүүнбүрэн сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2022 оны үйл ажиллагаанд зарцуулахаар төлөвлөсөн 544,573.4 мянган төгрөгийн санхүүжилтийг бүрэн төвлөрүүлж, төсвийн гүйцэтгэл 95.5 хувьтай тайлагнагдан, батлагдсан төсвийг 4.5 хувиар хэмнэсэн байна.

Аудитын гол асуудал

Тус байгууллагын 2022 оны нийт төсвийн зарцуулалт, ажил гүйлгээний 75.0 хувийг цалин хөлс, нэмэгдэл урамшил, ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардал, 1.4 хувийг байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, 12.7 хувийг нормативд зардал, урсгал засварын зардал 0.4 хувийг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил

018020297

үйлчилгээний төлбөр 0.1 хувийг, бараа үйлчилгээний бусад зардал 3.0 хувийг тус тус эзэлж байна.

Бусад асуудлын хэсэг

Аудит, аудиторын хариуцлага, аудитын тайлангийн тухай хэрэглэгчдэд хамаатай бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Ч.ЭНХТУЯА



АГУУЛГА

1. Аудитын дүгнэлт.....
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
 - 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....
 - 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....
 - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....
 - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт.....
 - 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....
4. Аудитын тайлан.....
 - 4.1 Ерөнхий зүйл
 - 4.2 Материаллаг байдал
 - 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....
 - 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
 - 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
 - 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал
5. Аудитын илрүүлэлт
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл.....

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БШУС	Боловсрол, шинжлэх ухааны сайд
БШУГ	Боловсрол, шинжлэх ухааны газар
БШУЯ	Боловсрол, шинжлэх ухааны яам
ЗГ	Засгийн газар
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сангаас
ХНХС	Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

□□□□□□ □□□	Балансын зүйл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	45,657,062.81	44,501,910.93
31	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	-	18,922,706.02
311	Кассанд байгаа	-	
312	Банкинд байгаа		18,922,706.02
33	АВЛАГА	-	-
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага		
35	БАРАА МАТЕРИАЛ	45,657,062.81	25,579,204.91
351	Түүхий эд материал	-	-
354	Хангамжийн материал	45,657,062.81	25,579,204.91
35410	Бичиг хэргийн материал	578,000.00	429,450.00
35420	Аж ахуйн материал	22,588,017.81	12,674,999.91
35460	Хүнсний материал	120,400.00	
35470	Бусад хангамжийн материал	22,370,645.00	12,474,755.00
356	Мал амьтад	-	-
36	НӨӨЦИЙН БАРАА		
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	697,301,548.51	717,919,003.06
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	697,301,548.51	717,919,003.06
392	Биет хөрөнгийн дүн	687,739,548.51	708,440,336.34
39201	Барилга байгууламж	679,136,448.42	709,136,301.42
39202	Хуримтлагдсан элэгдэл	(60,307,304.40)	(61,044,653.64)
39205	Машин тоног төхөөрөмж	40,882,848.00	44,482,848.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(5,610,749.83)	(14,298,027.92)
39207	Тавилга, эд хогшил	51,480,102.86	54,775,102.86
39208	Хуримтлагдсан элэгдэл	(28,613,110.74)	(35,124,316.22)
39209	Зам, гүүрийн байгууламж	1,084,000.00	1,084,000.00
39210	Хуримтлагдсан элэгдэл	(103,101.08)	(361,333.44)
39214	Бусад үндсэн хөрөнгө	13,234,713.00	13,234,713.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(3,970,413.72)	(3,970,413.72)
39217	Ном	526,116.00	526,116.00
393	Биет бус хөрөнгийн дүн	9,562,000.00	9,478,666.72
39301	Программ хангамж	250,000.00	250,000.00
39302	Хасагдуулга		(83,333.28)
39303	Бусад биет бус хөрөнгө	9,312,000.00	9,312,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	742,958,611.32	762,420,913.99
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	-
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	742,958,611.32	762,420,913.99
51	Засгийн газрын хувь оролцоо	742,958,611.32	762,420,913.99
511	Засгийн газрын оруулсан капитал	202,588,074.46	202,588,074.46
51101	Өмч: -төрийн	202,588,074.46	202,588,074.46
512	Хуримтлагдсан үр дүн	52,858,293.64	72,320,596.31
51210	Өмнөх үеийн үр дүн	59,006,135.75	52,858,293.64
51220	Тайлант үеийн үр дүн	(6,147,842.11)	19,462,302.67
51300	Дахин үнэлгээний зөрүү	487,512,243.22	487,512,243.22
6	ӨР ТӨЛБӨР БА ЭЗ/ӨМЧИЙН ДҮН	742,958,611.32	762,420,913.99

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН		
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	453,558,460.86	583,702,753.00
120	Нийтлэг татварын бус орлого	36,719,260.86	40,151,353.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	36,719,260.86	40,151,353.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		1,022,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	36,256,014.86	37,754,853.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	463,246.00	1,374,500.00
13	ТУСЛАМЖ САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	416,839,200.00	543,551,400.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	379,941,300.00	474,098,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт		474,098,600.00
131007	Тусгай зориулалтын шилжүүдгээс санхүүжих	379,941,300.00	
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	255,000.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хувиарласан хөрөнгө	255,000.00	
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	36,642,900.00	69,452,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	36,642,900.00	69,452,800.00
2	Үйл ажиллагааны зардал	459,444,081.37	564,240,450.33
21	Урсгал зардал	459,444,081.37	564,240,450.33
210	Бараа, үйлчилгээний зардал	448,532,281.07	558,455,064.92
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал	300,908,258.29	346,551,372.80
210101	Үндсэн цалин	255,966,100.34	271,283,514.38
210102	Нэмэгдэл цалин	26,734,202.06	70,461,534.57
210104	Урамшуулал	18,207,955.89	4,806,323.85
2102	Нийгмийн даатгалын шимтгэл	39,289,381.41	43,458,258.81
210201	Тэтгэврийн даатгалын	27,286,071.17	29,719,628.57
210202	тэтгэмжийн даатгалын	3,030,805.11	3,496,391.09
210203	ҮОМШӨ-ий даатгалын	2,394,403.97	2,773,632.72
210204	Ажилгүйдлийн даатгалын	592,091.10	671,512.82
210205	ЭМ-ийн даатгалын	5,986,010.06	6,797,093.61
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	36,120,000.00	45,203,976.96
210301	Гэрэл цахилгааны зардал	5,445,143.00	7,137,336.96
210302	Түлш, халаалтын зардал	29,570,257.00	36,962,040.00
210303	Цэвэр бохир усны зардал	1,104,600.00	1,104,600.00
2104	Хангамж, бараа материалын зардал	2,668,771.00	23,615,058.90
210401	Бичиг хэргийн зардал	91,200.00	
210404	Тээвэр шатахуун	264,600.00	
210403	Шуудан, холбоо, интернэтийн зардал	733,780.00	
210404	Ном, хэвлэл	82,700.00	
210405	Хог хаягдал устгах, цэвэрлэх	1,066,591.00	
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	429,900.00	
210408	Бараа материал акталсны зардал		23,615,058.90
2105	Нормативт зардал	20,724,980.00	66,354,700.00
210502	Хоол, хүнс	20,652,480.00	66,354,700.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлэгийн хэрэгсэл	72,500.00	
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,076,300.00	1,996,100.00
210604	Урсгал засварын зардал	1,076,300.00	1,996,100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажлын хөлс	1,591,500.00	370,700.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр	619,500.00	
210802	Аудит баталгаажуулалтын зардал	972,000.00	
210806	Мэдээлэл технологийн үйлчилгээ		370,700.00
2109	Бараа, үйлчилгээний бусад зардал	46,153,090.37	30,904,897.45
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		9,567,499.00
210902	Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал	1,817,700.00	4,200,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	44,335,390.37	17,137,398.45
213	Урсгал шилжүүлэг	10,911,800.30	5,785,385.41
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	5,785,385.41
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг		5,785,385.41
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	10,911,800.30	-
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	10,911,800.30	
3	Үйл ажиллагааны үр дүн	(5,885,620.51)	19,462,302.67
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	262,221.60	-
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	262,221.60	
4	Үйл ажиллагааны бус үр дүн	(262,221.60)	-
5	Үйл ажиллагааны нийт үр дүн	(6,147,842.11)	19,462,302.67

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	416,839,200.00	544,573,400.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО		1,022,000.00
120	Нийтлэг татварын бус орлого		1,022,000.00
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого		1,022,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		1,022,000.00
13	ТУСЛАМЖ САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	416,839,200.00	543,551,400.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	379,941,300.00	474,098,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт		474,098,600.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	379,941,300.00	
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	255,000.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хувиарласан хөрөнгө	255,000.00	
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	36,642,900.00	69,452,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	36,642,900.00	69,452,800.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	416,839,200.00	525,650,693.98
21	УРСГАЛ ЗАРДАЛ	416,839,200.00	525,650,693.98
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	405,927,399.70	519,865,308.57
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал	300,908,258.29	346,551,372.80
210101	Үндсэн цалин	223,143,502.40	271,283,514.38
210102	Нэмэгдэл	59,556,800.00	70,461,534.57
210103	Унаа хоолны хөнгөлөлт		
210104	Урамшуулал	18,207,955.89	4,806,323.85
2102	Ажил олгогчийн нийгмийн даатгалд төлөх шимтгэл	39,289,381.41	43,458,258.81
210201	Тэтгэврийн даатгалын	27,286,071.17	29,719,628.57
210202	Тэтгэмжийн даатгалын	3,030,805.11	3,496,391.09
210203	ҮОМШӨ-ий даатгалын	2,394,403.97	2,773,632.72
210204	Ажилгүйдлийн даатгалын	592,091.10	671,512.82
210205	Эрүүл мэндийн даатгалын	5,986,010.06	6,797,093.61
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	36,120,000.00	45,203,976.96
210301	Гэрэл цахилгааны зардал	5,445,143.00	7,137,336.96
210302	Түлш, халаалтын зардал	29,570,257.00	36,962,040.00
210303	Цэвэр бохир усны зардал	1,104,600.00	1,104,600.00
2104	Хангамж, бараа материал	2,403,580.00	-
210401	Бичиг хэргийн зардал	113,800.00	
210404	Тээвэр шатахуун	264,600.00	
210403	Шуудан холбооны зардал, мэдээлэл тех-гийн үйлчилгээ	733,780.00	
210404	Ном	82,700.00	
210405	Хог хаягдал устгах, цэвэрлэх	1,003,900.00	
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	204,800.00	
210408	Бараа материал акталсны зардал		
2105	Нормативт зардал	21,608,780.00	66,234,300.00
210501	Эм	72,500.00	
210502	Хоол, хүнс	20,772,880.00	66,234,300.00
210503	Нормын хувцас	763,400.00	
2106	Эд хогшил урсгал засвар	1,076,300.00	1,996,100.00
210604	Урсгал засвар	1,076,300.00	1,996,100.00
2107	Томилолт, зочны зардал	-	-
210702	Дотоодын томилолт		

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажлын, үйлчилгээний төлбөр, хураамж	2,606,000.00	962,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил , үйлчилгээний төлбөр, хураамж	1,634,000.00	
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	972,000.00	
210806	Мэдээлэл технологийн үйлчилгээ	-	962,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,915,100.00	15,459,300.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		11,259,300.00
210902	Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх	1,915,100.00	4,200,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	10,911,800.30	5,785,385.41
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг		
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэлт	10,911,800.30	5,785,385.41
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	10,911,800.30	5,785,385.41
3	Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	-	18,922,706.02
	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
4	Хөрөнгө оруулалтын мөнгөн орлогын дүн		
5	Хөрөнгө оруулалтын мөнгөн зарлагын дүн	-	-
22	Хөрөнгийн зардал	-	-
2200	Дотоод эх үүсвэрээр	-	-
223001	Бусад хөрөнгө		
6	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	-	-
7	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
145004	Дотоод эх үүсвэрээс олгосон зээлээс эргэж төлөгдөх		
8	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	-	18,922,706.02
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		18,922,706.02

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны үр дүн
А	1	2	3	4
2020 оны 12 дугаар сарын 31-нээрх үлдэгдэл	202,588,074.46	487,512,243.22	59,006,135.75	742,958,611.32
НББ-ийн бодлогын өөрчлөлт				-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл				-
ҮХ-ийн өсөлт, бууралт				-
ҮХ-ийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				-
Тайлант үеийн үр дүн				-
2021 оны 12 дугаар сарын 31-нээрх үлдэгдэл	202,588,074.46	487,512,243.22	52,858,293.64	742,958,611.32
НББ-ийн бодлогын өөрчлөлт				-
ҮХ-ийн өсөлт, бууралт				-
ҮХ-ийн дахин үнэлгээний бууралт				-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				-
Тайлант үеийн үр дүн			19,462,302.67	19,462,302.67
2022 оны 12 дугаар сарын 31-нээрх үлдэгдэл	202,588,074.46	487,512,243.22	72,320,596.31	762,420,913.99

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Д/Д	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	544,573,400.00	519,865,308.57	24,708,091.43	95.5
21	Урсгал зардлын дүн	544,573,400.00	519,865,308.57	24,708,091.43	95.5
210	Бараа үйлчилгээний зардал	544,573,400.00	519,865,308.57	24,708,091.43	95.5
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	364,846,165.43	346,551,372.80	18,294,792.63	95.0
210101	Үндсэн цалин	310,611,065.43	271,643,661.38	38,967,404.05	87.5
210102	Нэмэгдэл	50,190,800.00	70,101,387.57	(19,910,587.57)	139.7
210104	Урамшуулал	4,044,300.00	4,806,323.85	(762,023.85)	118.8
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	45,314,594.57	43,458,258.81	1,856,335.76	95.9
210201	Тэтгэврийн даатгал	30,813,499.86	29,719,628.57	1,093,871.29	96.5
210202	Тэтгэмжийн даатгал	3,625,523.69	3,496,391.09	129,132.60	96.4
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,900,198.94	2,773,632.72	126,566.22	95.6
210204	Ажилгүйдлийн даатгал	725,324.76	671,512.82	53,811.94	92.6
210205	ЭМД-ын хураамж+В21	7,250,047.32	6,797,093.61	452,953.71	93.8
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	45,715,640.00	45,203,976.96	511,663.04	98.9
210301	Гэрэл цахилгааны зардал	7,649,000.00	7,137,336.96	511,663.04	93.3
210302	Түлш, халаалтын зардал	36,962,040.00	36,962,040.00	-	100.0
210303	Цэвэр бохир усны зардал	1,104,600.00	1,104,600.00	-	100.0
2105	Нормативт зардал	70,279,600.00	66,234,300.00	4,045,300.00	94.2
210501	Эм			-	
210502	Хоол хүнс	70,279,600.00	66,234,300.00	4,045,300.00	94.2
210503	Нормын хувцас зөөлөн эдлэл			-	
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,996,100.00	1,996,100.00	-	100.0
210604	Урсгал засвар	1,996,100.00	1,996,100.00	-	100.0
2107	Томилолт, зочны зардал	-	-	-	
210702	Дотоод томилолт			-	
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр	962,000.00	962,000.00	-	100.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр			-	
210806	Мэдээлэл технологийн үйлчилгээ	962,000.00	962,000.00	-	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	15,459,300.00	15,459,300.00	-	100.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	11,259,300.00	11,259,300.00	-	100.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,200,000.00	4,200,000.00	-	100.0
1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	544,573,400.00	519,865,308.57	24,708,091.43	95.5
131	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	474,098,600.00	455,175,893.98	18,922,706.02	96.0
131001	Улсын төсвөөс санхүүжих	474,098,600.00	455,175,893.98	18,922,706.02	96.0
132	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	69,452,800.00	63,667,414.59	5,785,385.41	91.67
132001	Орон нутгийн төсвөөс	69,452,800.00	63,667,414.59	5,785,385.41	91.67
120	Төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлогоос	1,022,000.00	1,022,000.00	-	100.0
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос	1,022,000.00	1,022,000.00	-	100.0
002	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00	-	100.0

003	Төсвийн байгууллага	1.00	1.00	-	100.0
	АЖИЛЛАГСДЫН ТОО	29.00	29.00	-	100.0
	Удирдах ажилтан	1.00	1.00	-	100.0
	Гүйцэтгэх ажилтан	20.00	20.00	-	100.0
	Үйлчлэх ажилтан	8.00	8.00	-	100.0
010	СУРАЛЦАГЧДЫН ТОО /ЖИЛИЙН ДУНДЖААР/	179.00	179.00	-	100.0
015	Төрийн өмчит СӨБ байгууллага	179.00	179.00	-	100.0
024	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ			-	
028	СӨБ болон бага, дунд боловсролын албан хаагч /ТҮБД/	20.00	20.00	-	100.0
033	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч	9.00	9.00	-	100.0

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Зүүнбүрэн сумын 1 дүгээр цэцэрлэг нь “Хүүхэд бүрийн сурч төлөвших нөхцөлийг бүрдүүлж, эрүүл аюулгүй орчин нөхцөлийг бий болгон, багш мэргэжлээрээ тасралтгүй хөгжих боломжийг бүрдүүлэхэд оршино.” гэсэн эрхэм зорилгын хүрээнд үйл ажиллагаагаа явуулсан байна.

Үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Хүүхэд бүрийн сурч хөгжих, төлөвших, эрүүл аюулгүй орчин нөхцөлийг бүрдүүлэхийн тулд багш, эцэг эх хамтран ажиллаж, үр дүнг тооцох,
- Сум орон нутгийн 5 настай хүүхэд бүрийг сургуулийн өмнөх боловсролд тэгш хамруулан сургуульд суралцах бэлтгэлийг хангах,
- Хүүхдийг шим тэжээллэг хоол хүнсээр хангах, зохистой дадал хэвшилд сургах, байгууллагын хоол үйлдвэрлэл, үйлчилгээний чанарыг сайжруулах
- Багш бүр ажлын байран дээрээ тасралтгүй хөгжих боломжит хэлбэрүүдийг ашиглан заах арга зүй, ур чадвараа хөгжүүлэх,
- Сургалтын орчныг сайжруулах, аюулгүй байдлын стандарт, шаардлагад нийцүүлэх, өндөржүүлсэн бэлэн байдал болон эрсдэлээс урьдчилан сэргийлэх ажлыг үр дүнтэй зохион байгуулж ажиллах,
- Хүүхдийн хүмүүжил, хөгжил, хамгааллын асуудлаар эцэг эх, асран хамгаалагчтай гурвалсан гэрээ байгуулж тэдний үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх,
- Багш, туслах багш, ажилтан бүр нь ажлын байрандаа сахилга хариуцлагыг чандлан сахиж, ёс зүйн хэм хэмжээг баримтлан бүтээлчээр ажиллах,

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2022 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилтийг баталсан,
- Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдсөн байна.
- Төрийн хэмнэлтийн тухай тухай хууль хэрэгжиж эхэлсэн,
- Төрийн албаны тухай хуульд 2022 оны 04 дүгээр сарын 22, 07 дугаар сарын 05, 11 дугаар сарын 11-нд нэмэлт өөрчлөлт орсон.
- Боловсролын тухай хуульд 2022 онд 3 удаа нэмэлт өөрчлөлт орсон,
- ЗГ-ын 2022 оны 91 дүгээр тогтоолоор батлагдсан “Хувьсах зардлын дундаж норматив, аргачлал батлах тухай” журам хэрэгжиж эхэлсэн,
- ЗГ-ын 2019 оны 472 дугаар тогтоолын 5, 6 дугаар хавсралтаар батлагдсан “Шинжлэх ухааны байгууллага, сургуулийн өмнөх болон бага, дунд боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллагын төрийн үйлчилгээний

албан тушаалын цалингийн сүлжээ батлах тухай ” тогтоолд 2022 оны 107 дугаар тогтоолоор батлагдсан “Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг тогтоох тухай” тогтоол, 2022 оны 192 дугаар тогтоолоор нэмэлт өөрчлөлт оруулсан,

- ЗГ-ын 2019 оны 5 дугаар тогтоолын гуравдугаар хавсралтаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын багш, туслах багш, албан хаагчид олгох улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгох” тогтоолд 2022 оны 252 дугаар тогтоолоор нэмэлт өөрчлөлт оруулсан,
- БШУС-ын 2022 оны А/170 дугаар тушаалаар батлагдсан “Хичээл, сургалтын үйл ажиллагааны зардлыг төлөвлөх, хуваарилах заавар”-ыг хэрэгжүүлж эхэлсэн,
- БШУС-ын 2022 оны А/465 дугаар тушаалаар батлагдсан “Ерөнхий боловсролын сургуульд, кабинет, лаборатори, цахим сургалтын танхим байгуулах, ашиглах нийтлэг журам”-ыг шинэчлэн баталсан,
- ХНХС-ын 2021 оны А/192 дугаар тушаалаар батлагдсан “Дундаж цалин хөлс тодорхойлох журам” хэрэгжиж эхэлсэн.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналт, үйл ажиллагааны зохион байгуулалтын хэрэгжилт үр нөлөөтэй гэж үзлээ.

Тайлант онд дээд шатны төсвийн захирагчийн зүгээс дотоод аудитын хяналт, шалгалт хийгдээгүй, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Зүүнбүрэн сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн, хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

Тус байгууллага нь өмнөх онуудад тусгай зориулалтын шилжүүлгээр санхүүждэг байсны хувьд Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2020 оны А/202 тоот захирамжаар баталсан Сэлэнгэ аймгийн ТЭЗ-ийн харьяа төсөвт байгууллагууд дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг тайлант онд мөрдөж ирсэн байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн хэдий ч гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжиж байгаа байгууллагын онцлогт тохироогүй, үр дүнд суурилсан төсөвлөлт, санхүүжилт, хөрөнгө оруулалт, хөтөлбөр, арга хэмжээний бүртгэлийн талаар нарийн тусгаагүй өөрөөр хэлбэл боловсролын салбарын онцлогт тохирохгүй байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Зүүнбүрэн сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 19,462.3 мянган төгрөгөөр буюу 2,6 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө		18,922.7	18,922.7
Авлага	-	-	-
Бараа материал	45,657.1	25,579.2	(20,077.9)
Үндсэн хөрөнгө	697,301.5	717,919.0	20,617.5
Нийт хөрөнгө	742,958.6	762,420.9	19,462.3
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	742,958.6	762,420.9	19,462.3
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	742,958.6	762,420.9	19,462.3

Тайлант жилийн үйл ажиллагааны зардлын хэмнэлт 18,922.7 мянган төгрөгийг Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралт “Хувьсах зардлын дундаж нормативаар төсөв хуваарилах, санхүүжүүлэх аргачлал”-ын 8.7-д “Боловсролын сургалтын байгууллагын жилийн эцсийн дансны үлдэгдлийг дараагийн төсвийн жилд шилжүүлнэ.” гэж заасны дагуу төрийн сангийн харилцах дансанд үлдэгдлээр тайлагнагдсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 25,579.2 мянган төгрөг болж 20,077.9 мянган төгрөгөөр буурсан нь төсвийн хөрөнгөөр 80,946.5 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, БШУЯ-наас 323.5 мянган төгрөгийн кварцын гэрэл, бичиг хэргийн материал, эцэг эхийн зөвлөлөөс 1,051.0 мянган төгрөгийн тоглоомыг үнэ төлбөргүй орлогоор бүртгэж авсан бөгөөд үйл ажиллагаанд 78,783.8 мянган төгрөгийн хөрөнгийг зарцуулан, Эрхлэгчийн 2022 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн А/11 дугаар тушаалаар эдэлгээний хугацаа дуусаж, аюулгүй байдал,

сургалтын стандартын шаардлага хангахгүй болсон 23,615.1 мянган төгрөгийн бараа материалыг акталснаас шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл /анхны өртгөөр/ 832,801.1 мянган төгрөг болж 36,894.8 мянган төгрөгөөр өссөн нь БШУЯ-наас 3,600.0 мянган төгрөгийн 2-р хоолны тогоо, эцэг эхийн зөвлөлөөс 3,295.0 мянган төгрөгийн хүүхдийн сургалтын хэрэглэгдэхүүн, Зүүнбүрэн сумын ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 29,999.8 мянган төгрөгийн дээвэр засварыг үнэ төлбөргүй хүлээн авч, 860,0 мянган төгрөгийн тэг үлдэгдэлтэй үндсэн хөрөнгийг дахин үнэлж, орлогод авсантай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 762,420.9 мянган төгрөг болж 19,462.3 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 503,254.5 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 50,815.7 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 554,070.2 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас цалингийн зардлыг 8,330.1 мянган төгрөгөөр, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 1,041.0 мянган төгрөгөөр, урсгал засварын зардлыг 1,603.9 мянган төгрөгөөр өсгөн, байр ашиглалттай холбоотой зардлыг 1,500.0 мянган төгрөгөөр, хангамж бараа материалын зардлыг 2,577.6 мянган төгрөгөөр, нормативт зардлыг 16,030.9 мянган төгрөгөөр, томилолтын зардлыг 410.4 мянган төгрөг тус тус бууруулж, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ 24.6 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардлыг 231.5 мянган төгрөгөөр тус тус нэмэгдүүлэн нийт төсвийг 522,832.4 мянган төгрөгөөр баталсан байна.

2022 оны 12 дугаар сард хийсэн төсвийн зохицуулалтаар цалингийн зардлыг 19,584.4 мянган төгрөгөөр, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 2,156.7 мянган төгрөг тус тус нэмж 544,573.4 мянган төгрөгийн эх үүсвэрийг баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 13 арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвөөс 474,098.6 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 69,452.8 мянган төгрөг, төсөвт байгууллагын өөрийн орлого 1,022.0 мянган төгрөг

нийт 544,573.4 мянган төгрөгийн эх үүсвэрийг урсгал үйл ажиллагаанд захиран зарцуулахаар төлөвлөгдсөн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 519,865.3 мянган төгрөг буюу 95.5 хувьтай байгаа нь цалингийн зардлаас 18,294.8 мянган төгрөг, НДШ-ийн зардлаас 1,856.3 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 511.7 мянган төгрөг, хүүхдийн хоолны зардлаас 4,045.3 мянган төгрөг нийт 24,708.1 мянган төгрөгийг хэмнэснээс шалтгаалсан байна. .

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

		/мянган төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр	д/д	Арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	зөрүү	Биелэлт
	71801- Сургуулийн өмнөх боловсрол	1	81605- Эрүүл мэндийг дэмжих	1,300.0	1,300.0	0	100.0
		2	81807-Цэцэрлэгийн хүүхдийн хоол	70,279.6	66,234.3	4,045.3	94.24
		3	81816- Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	1,601.3	1,601.3	0	100.0
		4	81823- Боловсролын багшийн сургалт	1,300.0	1,300.0	0	100.0
		5	81834- Боловсролын стандарт сургалт	349,514.5	336,846.1	12,668.4	96.37
		6	81835- Сургалтын хэвийн үйл ажиллагаа	50,103.2	47,894.2	2,209.0	95.59
		7	81844- Гүнзгийрүүлсэн болон төрөлжсөн	1,022.0	1,022.0	0	100.0
		8	80111- Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	52,985.5	52,473.8	511.7	99.0
		9	80112- Нийтлэг үйлчилгээ	16,467.3	11,193.6	5,273.7	66.9
		Нийт		544,573.4	519,865.3	24,708.1	95.5

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансанд орлого, зарлагын гүйлгээ хийгдээгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Зүүнбүрэн сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн байгууллагын санхүүгийн тайлангийн тайлбар тодруулгатай холбоотой болон худалдан авалтыг бараа, ажил, үйлчилгээний нэр төрөл, тоо хэмжээг тусгасан төлбөрийн цахим баримтаар баталгаажуулахтай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний дагуу “ЦЭСБ-Аудит” ХХК-ийн аудитор Ш.Ганчимэг гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Зүүнбүрэн сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг “ЦЭСБ-Аудит” ХХК-д 2023 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 01 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн шатны материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 460,458.6 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 4,604.6 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Боловсролын ерөнхий газраас нийт боловсролын байгууллагуудад 2022 оны 04, 09 дүгээр саруудад төрийн хэмнэлтийн тухай хууль болон ЗГ-ын 2022 оны 203 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах, төсвийн хэмнэлтийн горимоор ажиллах, орон тоог хязгаарлах, төрийн үйл ажиллагааг цахимжуулах, бараа үйлчилгээний зардлыг бууруулах, зөвлөмжийг хүргүүлсэн байна.

Зүүнбүрэн сумын 1 дүгээр цэцэрлэг нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийг дараах байдлаар хэрэгжүүлжээ. Үүнд:

- Боловсролын салбарын үр дүнд суурилсан санхүүжилтийг нэвтрүүлж батлагдсан орон тоогоор бус гүйцэтгэлээр санхүүжүүлсэнтэй холбоотойгоор цалин, ажил олгогчоос төлөх НДШ болон бусад зардлаас нийт 24,708.1 мянган төгрөгийн хэмнэлтийг бий болгожээ.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд боловсролын байгууллагын мэдээлбэл зохих 20 төрлийн 149 мэдээллээс 1 мэдээллийг хугацаа хоцроож, 148 мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

“ЦЭСБ-Аудит” ХХК-ийн 2022 оны 11 дүгээр 21-ний 208 дугаар албан бичгээр “Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай” захидлыг хүргүүлсэн бөгөөд тус байгууллагын 2022 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланд хийсэн завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар дээд шатны төсвийн захирагчийн шийдвэргүйгээр улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулалд олгосон 183.3 мянган төгрөгийн зөрчил илэрч зөрчлийг арилгах төлбөрийн акт, төлбөрийн цахим баримттай холбоотой 1,375.2 мянган төгрөгийн зөрчлийг арилгах зөвлөмж өгснийг бүрэн хэрэгжүүлж ажилласан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	183.3	1	183.3	100.0
Зөвлөмж	1	1,375.2	1	1,375.2	100.0
Нийт дүн	2	1,558.5	2	1,558.5	100.0

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар дараах асуудлуудыг анхааран авч үзэх нь зүйтэй. Үүнд:

1. Дээд шатны төсөв захирагчаас төсвийг зардлын эдийн засгийн ангиллаар нь бус “бараа үйлчилгээний бусад зардал” гэсэн ангиллаар бөөнд нь тусган, төлөвлөж, баталж байгаа нь төсвийг зардлын бүлэг, зүйлээр төлөвлөж, зарцуулах, зарцуулалтад хяналт тавих зарчмыг алдагдуулж байна. Иймд төсвийг бодит гүйцэтгэлтэй нь уялдуулан зардлын бүлэг, зүйл бүрээр төлөвлөж, зарцуулан гүйцэтгэж байх шаардлагатай байна.
2. Сангийн яамны 2022 оны 02 дугаар сарын 28-ны “Чиглэл хүргүүлэх тухай” албан бичгээр байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансыг хааж нэмэлт санхүүжилттэй холбоотой гүйлгээг урсгал дансаар дамжуулан “Нэмэлт - Дээд шатны төсвөөс хуваарилсан” гэсэн зориулалтаар, төсөвт байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлого / 120010 / ангиллаар гүйцэтгэхээр чиглэл хүргүүлсэн байна. Нэмэлтээр хуваарилах төсвийн эх үүсвэрийг төсвийн санхүүжилтийн эх үүсвэр болгон төлөвлөж байгаагаас гүйцэтгэлээр уг санхүүжилт хуваарилагдаагүй тохиолдолд төсвийн санхүүжилтийн төлөвлөгөө тасарснаар тайлагнагдах эрсдэлийг үүсгэж байна. Иймд дээд шатны төсвөөс хуваарилах нэмэлт төсвийг төсвийн санхүүжилт хэлбэрээр урьдчилан төлөвлөж, батлалгүйгээр санхүүжилт ирсэн тухай бүр тухайн санхүүжилтийн дүнгээр зарцуулах эрх тавих нь зүйтэй юм.
3. Тус байгууллага нь өмнөх жилүүдэд тусгай зориулалтын шилжүүлгээр санхүүждэг байсан учир Сэлэнгэ аймгийн ЗД-ын 2020 оны 7 дугаар сарын 16-ний өдрийн А/202 дугаар захирамжаар баталсан “Сэлэнгэ аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн багцад хамаарах төсөвт байгууллагуудад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг мөрдөж ирсэн байна. Бүртгэлийн үйл ажиллагаанд мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн хэдий ч боловсролын байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирохгүй учир төсвийн ерөнхийлөн захирагчийн боловсруулсан НБББББ-ыг мөрдөх нь зүйтэй юм.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар алдаа илрээгүй болно.

Аудитаар нийт 11,572.6 мянган төгрөгийн зөрчил илэрч 196.3 мянган төгрөгийн 1 албан шаардлага, 11,376.3 мянган төгрөгийн 2 зөвлөмж өглөө.

5.1 Албан шаардлага

1. Цэцэрлэгийн нэг хүүхдэд ногдох хоногийн хоолны зардлыг нийт 196.3 мянган төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Засгийн газрын “Хоолны зардлын норматив тогтоох тухай” 2019 оны 450 дугаар тогтоолын 1 дэх *Цэцэрлэгийн хүүхэд бүрийн нэг өдрийн хоолны зардлыг 8-10 цагаар ажилладаг цэцэрлэгт 2475 (хоёр мянга дөрвөн зуун далан таван) төгрөгөөр, 24 цагаар ажилладаг, сувиллын болон тусгай цэцэрлэгийн хүүхэд бүрийн нэг өдрийн хоолны зардлыг 3600 (гурван мянга зургаан зуун) төгрөгөөр тус тус тогтоосугай.*” гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Норм, нормативыг мөрдөж ажиллах албан шаардлага өгөх.

5.2.Зөвлөмж

1. Анхан шатны баримт бүрдүүлэлттэй холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт: Тайлант онд нийт 11,376.3 мянган төгрөгийн хүнсний материалын худалдан авалтын цахим төлбөрийн баримтыг нэр төрөл, тоо хэмжээ тус бүрээр бус бөөн дүнгээр баталгаажуулсан нь Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтын 6.5 дахь “ ... Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана. ...” гэсэн заалтыг зөрчсөн байна.

1.2 Өгсөн зөвлөмж: Худалдан авалтыг бараа, ажил, үйлчилгээний нэр төрөл, тоо хэмжээ нэг бүрийг тусгасан төлбөрийн цахим баримтаар баталгаажуулж байх.

2.Санхүүгийн тайлантай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт: Санхүүгийн тайлангийн тайлбар, тодруулгыг иж бүрэн хийгээгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дахь “Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлангаа гаргах үүрэг бүхий аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайлан нь дараах бүрэлдэхүүнтэй байна”, 8.1.5 дахь “санхүүгийн тайлангийн тодруулга” гэсэн заалттай нийцэхгүй байна.

2.2 Өгсөн зөвлөмж: Байгууллагын санхүүгийн үйл ажиллагаа, нягтлан бодох бүртгэл, онцлог байдлыг илтгэсэн тайлбар, тодруулгуудыг хийж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс /мянган төгрөгөөр/									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Хоолны зардлын нормативыг хэтрүүлэн зарцуулсан.	1	196.3			1	196.3						
худалдан авалтын цахим төлбөрийн баримтыг бөөн дүнгээр баталгаажуулсан	1	11,376.3					1	11,376.3				
Тайлбар тодруулгыг хийж байх	1						1					
Дүн	3	11,572.6			1	196.3	2	11,376.3				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс /мянган төгрөгөөр/					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Дүн								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн								